



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 6 дугаар
сарын 8-ны өдөр

Дугаар 233

Улаанбаатар
хот


Гадаадаас ажиллах хүч,
мэргэжилтэн авах тухай

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 7.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсад 2015 онд хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг хавсралтад заасан аж ахуйн нэгжид зохих журмын дагуу олгохыг Хөдөлмөрийн сайд С.Чинзоригт зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын дагуу авч ажиллуулах гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг 2015 онд буцаан гаргах ажлыг зохион байгуулж, дүнг Хөдөлмөрийн яаманд хүргүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Д.Цогтбаатар, Зам, тээврийн сайд Н.Төмөрхүү, Уул уурхайн сайд Р.Жигжид нарт даалгасугай.

3. Мэргэжилтэй ажиллах хүчнийг дотооддоо сургаж бэлтгэх, мэргэжлийн өндөр ур чадвартай гадаадын мэргэжилтнийг дагалдуулан мэргэшүүлэх арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөрийн сайд С.Чинзоригт, уг үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг холбогдох сайд нарт тус тус үүрэг болгосугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Хөдөлмөрийн сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

С.ЧИНЗОРИГ

МОНГОЛ УЛСАД 2015 ОНД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Гүйцэтгэх үйл ажиллагаа	Гадаадын ажиллах хүч, мэргэжилтний тоо
Уул уурхай, газрын тосны салбарт			
1	"Капкорл Монголиа" ХХК	Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай аймгийн нутагт "Богд-IV", "Онги-У" талбайд геохими, чичирхийллийн хэмжилт, агаарын бүрэн хэмжээст соронзон болон хүндийн хүчний судалгаа, өрөмдлөгийн ажил гүйцэтгэх	46
2	"Монголиа Гладвилл Увс Петролиум" ХХК	"Увс-I" талбайд агаарын болон соронзон, хүндийн хүчний судалгаа болон өрөмдлөгийн ажил гүйцэтгэх	96
3	"Эн Пи Ай" ХХК	Дорнод аймагт "Хөх нуур-ХVIII" гэрээт талбайд өрөмдлөг, 2 болон 3 хэмжээст чичирхийллийн судалгаа, цооногийн туршилтын ажил гүйцэтгэх	43
4	"Эс Пи Эй Ар" ХХК	Дорнод аймгийн Дашбалбар суманд Улааны полиметаллын ордод "Шинь Шинь" ХХК-тай гэрээний дагуу баяжуулах үйлдвэрийн хаягдлын сангийн засвар, задарсан даланг шинээр байгуулах, шүүрэлтээс хамгаалах байгууламж шинэчлэх, технологийн шугам хоолойн дахин төлөвлөлт, суурилуулалтын ажил гүйцэтгэх	75
Авто замын салбарт			
5	"Самсунг Си энд Ти" ХХК	Улаанбаатар хотод Олон улсын нисэх онгоцны буудлын шинэ барилгын ажил гүйцэтгэх	120
Барилгын салбарт			
6	"Авторстрой" ХХК	Баянхонгор аймгийн Баянхонгор сум, нийслэлийн Баянзүрх дүүрэгт орон сууц, бизнес хөгжлийн төвийн барилгын ажил гүйцэтгэх	200
7	"Басмааконстракшн" ХХК	Чингэлтэй дүүргийн 7 дугаар хороонд гэр хорооллын дахин төлөвлөлт төслийн хүрээнд 1072 айлын орон сууц, 640 хүүхдийн сургууль, 250 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажил гүйцэтгэх	100
8	"Баянбогд сончин" ХХК	Баянзүрх дүүргийн 25 дугаар хороонд "Макс өргөө" ХХК-ийн захиалгаар "Хийморь-13" үйлчилгээний төвтэй 360 айлын орон сууцны барилгын ажил гүйцэтгэх	80

9	"БУТОЗМ" ХХК	Баянзүрх дүүрэгт ШУТИС-ийн багш, ажилчдын 60 айлын, мөн дүүргийн 8 дугаар хороонд 50 айлын түр шилжүүлэн байршуулах орон сууц, Дархан-Уул аймгийн Дархан сумын 12 дугаар багт 9 давхар 164 айлын орон сууцны барилгын ажил гүйцэтгэх	150
10	"Грийнресурс констракшн" ХХК	Баянгол дүүргийн 7 дугаар бичил хороололд 224 айлын 2 блок орон сууц, Баянзүрх дүүрэгт Хууль зүйн яамны захиалгаар Хууль сахиулах их сургуулийн 3000 сонсогчийн хичээлийн байр, Баянзүрх дүүргийн 25 дугаар хороонд "Ноголис" ХХК-ийн захиалгаар 56 айлын орон сууцны барилгын ажил гүйцэтгэх	80
11	"Гэрэлтцаст оргил" ХХК	Сүхбаатар дүүрэгт иргэн Ж.Баяраа, Баянгол дүүрэгт иргэн Н.Батжаргалын захиалгаар худалдаа, үйлчилгээ, албан газрын барилгын ажил, Баянзүрх дүүргийн 2, 3, 4, 5, 8, 9 дүгээр хороонд гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн туслан гүйцэтгэгчийн ажил гүйцэтгэх	80
12	"Дун-Юань" ХХК	Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хорооны Эмээлт тосгонд "Мал, махны төрөлжсөн худалдааны төв"-ийн барилгын ажил гүйцэтгэх	170
13	"Ихтайж констракшн" ХХК	Баянзүрх дүүрэгт шинэ технологээр баригдах "Арцат" хотхоны 16 давхар 320 айлын үйлчилгээний төвтэй орон сууцны барилгын ажил гүйцэтгэх	150
14	"НАЗУК" ХХК	Баянгол дүүргийн 20 дугаар хороонд автомашины 3 давхар зогсоол барих ажил гүйцэтгэх	110
15	"Назу проперти" ХХК	Сонгинохайрхан дүүргийн 10 дугаар хороонд "Баян далай хороолол"-ын 7340 айлын барилгын ажил гүйцэтгэх	150
16	"Өвөр-Аргалант" ХХК	Хан-Уул дүүргийн 2 дугаар хороонд "Туул" хотхоны 120 айлын 3 блок барилга угсралтын ажил гүйцэтгэх	80
17	"Сибирь-интернэшнл" ХХК	Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороо болон Баянзүрх дүүргийн 12 дугаар хороонд тус тус гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн дагуу орон сууцны барилгын ажил гүйцэтгэх	200
18	"Пи Ай Эм Эм" ХХК	"Шинэ яармаг" төслийн эхний ээлжийн "Голомт констракшн" ХХК-ийн 576 айлын орон сууцны барилгын туслан гүйцэтгэгчийн ажил гүйцэтгэх	50
19	"Халла гонсол" ХХК	Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хороонд "Улаанбаатар хотын захиргааны шинэ цогцолбор" төслийн барилгын ажил гүйцэтгэх	300

20	“Эм Си Эс проперти” ХХК	Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороонд “Шангри-Ла” зочид буудлын барилгын ажил гүйцэтгэх	500
21	“Эх тэргүүн” ХХК	Баянзүрх дүүргийн 11, 16 дугаар хороонд барилгын ажил гүйцэтгэх	200